

Булган аймагт “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг орон нутгийн эмэгтэйчүүд, албан тушаалтнаар хэлэлцүүлэх, УИХ-ын эмэгтэй гишүүдийн бүлэгтэй цахим хурал хийх ажлыг зохион байгуулсан тайлан

2015.04.25

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг 2015 оны 04 сарын 22-ны өдрийн 17,00 цагт Иргэний танхимд зохион байгуулав.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.Хэлэлцүүлгийн тайлан

Нэг.Оролцогчдын тоо, бүрэлдэхүүн

Аймгийн ИТХ-ын төлөөлөгч эмэгтэйчүүд, нийгмийн хөгжлийн хэлтэс, эрүүл мэндийн газар, нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн газар, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Өрхийн эмлэнэг, Нэгдсэн эмнэлэг, Багийн Засаг дарга нар, Хүчирхийллийн эсрэг Булган төв, Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан төрийн бус байгууллагууд, аймгийн ГХУСАЗЗ-ийн гишүүд зэрэг газарт хэлэлцүүлгийн урилга, хуулийн төслийг хэвлэн хүргүүлэв.

Аймгийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдөөс аймгийн ЗДО Д.Чимгээ оролцож, Хууль зүйн хэлстийн дарга П.Хишигдаваа хэлэлцүүлгийг хөтлөн явууллаа.

Эрүүл мэндийн салбарт магадлан итгэмжлэлийн шалгалт ажиллаж байна гэдэг шалтгаанаар өрхийн эмч нар, нэгдсэн эмнэлэгийн дарга нар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулгантай гэдэг шалтгаанаар Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга нар оролцоогүй бөгөд нийт 25 оролцогч хүрэлцэн ирлээ.

Оролцогчдын бүрэлдэхүүнийг тоогоор илэрхийлбэл: Аймгийн хурлын төлөөлөгч-1, Багийн ЗД-4, Хууль зүйн хорооны гишүүд-4/шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, өмгөөлөгч/ХГБХХэлтэс-2, НХХ-1, ГХУСАЗЗ-2, ЦГ-5, ТББ-3, Нийгмийн ажилтан-2, Хүний эрх-1

Хоёр.Хэлэлцүүлгээр хөндөгдсөн асуудал:

Хэлэлцүүлэгт оролцогчид дараах асуудалд анхаарлаа хандуулж байлаа. Үүнд:

-Хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн нотлох баримтыг үнэлэх, цуглуулах, хадгалах асуудал

-Урьдчилан сэргийлэх чиглэлээрх үйл ажиллагааг тодорхой болгох, тусгай бүлэг болгох

-Эрх зүйн эх сурвалжуудыг илүү өргөн хүрээгээр томъёолох

-Аймгуудад түр хамгаалах байр заавал байхаар хуульчлах

-Аймгийн ИТХ, ЗД-ын бүрэн эрх дээр шалтгааныг арилгах арга хэмжээ авахыг тодорхой тусгах

-Мэдээлэл өгсөн гэрч хохирогчийг хамгаалах асуудал, нууцлалыг хангах

-Сум, багийн ЗД-ыг дуудахад ирэхгүй байгаа хүчирхийлэл үйлдэгчэд ямар хариуцлага хүлээлгэх вэ ?

-Хөтөлбөр, хуулийн хэрэгжилтэнд мониторинг хийх санхүүжилтыг тодорхой тусгах

Гурав.Хэлэлцүүлгээс гарсан саналууд

3.1.Хуулийн зүйл заалтанд гаргасан саналууд:

21.1.2 дах хэсгийн ...нийгмийн ажилтан... гэдгийг тодорхой болгох

13.1.5 дах хэсэгт ...холбогдох дүрэм, журам... гэдгийг ...үлгэрчилсэн дүрэм... гэж өөрчлөх/учир нь орон нутаг, сургууль бүр өөрийн онцлогт тохируулан баталж байвал зохистой гэв/

9. 1 – дэх хэсэгт “Хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төсвийг улсын төсөвт тусган батлуулах” гэж нэмэх

19.1.4-д заасан стандартыг яамнаас боловсруулж батлуулахаар өөрчлөх

17.1 дүгээр зүйлд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх салбар зөвлөлийн санхүүжилт нь ГУСАЗЗ-ийн төсвийн 20 хувиас багагүй байна” гэж тодорхой оруулах

2.1.1 дэх Эрүүгийн хууль, ЭБШ хууль, Зөрчлийн тухай хууль г.м-ыг нэмж тусгах

5.1.9 дэх хэсэгт заасан “гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ” гэдгийг туслалцаа, дэмжлэгийг тодорхойлсон дүгнэлтийг гэж тодорхойлжээ. Үүнтэй холбогдуулаад 16 дугаар зүйл дээр 16.1 дэх хэсэгт ...нарийвчлан судалж дүгнэлт гаргах, ... гэжээ. Энэ хоёр холилдож ойлгогдож байна. Иймээс 16.1 дэх хэсгийн дүгнэлтийг өөрөөр томъёолох. Учир нь Прокурорын байгууллага дүгнэлт гаргах чиг үүрэггүй байгууллага юм.

5.1.1.-д “гэр бүлийн хүчирхийлэл” гэж тодорхойлоод 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5-д хэлбэрүүдийн тайлбарласан байгааг өөрчилж хэлбэрүүдийн тайлбарыг 5.1.1.1, 5.1.1.2, 5.1.1.3, 5.1.1.4 гэж оруулах.

21.1.3-д хэсгийг тодорхой нэршлээр нь зааж өөрчлөх

17,18 дугаар зүйлүүдэд “Гэр бүлийн хүчирхийлэлийн шалтгаан нөхцлийг арилгах зорилгоор өрх, гэр бүлийн эдийн засаг, хөгжлийн дэмжих /тодорхой зааж/ арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж нэмж оруулах

3.2.Төсөвтэй холбоотой дараах зүйлийн саналууд гарсан. Үүнд:

-Хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээний зардлыг улсын төсвөөс шийдвэрлэж байхаар хуульчлах

-Гэрээгээр ажил үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бус байгууллагууд ямар төрлийн үйлчилгээг гэрээдэн гүйцэтгэж болох, тэдэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг улсын төсвөөс шийдвэрлэж байхыг тодорхой тусгах

-Хууль, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийх ажлыг хуульчилж, санхүүгийн дэмжлэгийг хуульд тусгаж өгөх

3.3.Эрүүгийн хууль, эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төслийн хэлэлцүүлгүүд явагдаж байгаа. Энэ хуультай уялдуулаад дараах саналыг гаргаж байна. Үүнд:

-Гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдалд гэр бүлийн хүчирхийлэлт үйлдэж хийсэн байдлыг оруулах, нөгөө талаар гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байхдаа гэмт хэрэг үйлдсэн байдлыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцохоор хуулийн төсөлд санал оруулах

-Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэр бүлийн хүчирхийллийн хэрэг зөрчлийг шалгаж, шийдвэрлэхдээ хохирогч, мэдээлэгчийн аюулгүй байдал, нууцлалыг хангаж хамгаалах асуудлыг хуульчилж өгөх

Дөрөв.Хэлэлцүүлгийг зохион байгуулахад эерэгээр нөлөөлсөн хүчин зүйлс

Хэлэлцүүлгийн удирдамж, чиглэл, санхүүгийн тэтгэлгийг шуурхай шилжүүлэн мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангаж ажилласан нь зохион байгуулалтын саатах зүйлгүй байлаа.

Гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэх, түүний шалтгаан нөхцлийг арилгах, хүчирхийлэлтэй холбоотой ул суурьтай тоон мэдээ, мэдээллийн сан бүрдүүлэлтийн асуудал орон нутгийн удирдлага хийгээд мэргэжлийн байгууллагуудын тулгамдсан асуудал болсон тул энэхүү хуулийн хэлэлцүүлэгийг судлуулах, санал гаргуулах асуудал нь нийгмийн захиалга, хэрэгцээ шаардлагад нийцсэн ажил байлаа.

Тав.Хэлэлцүүлэг зохион байгуулахад гарсан хүндрэл бэрхшээлүүд

Орон нутагт зохион байгуулагдаж байгаа цаг үеийн ажлуудтай давхцсан нь оролцогчдын оролцоог бүрэн хангахад хүндрэлтэй байлаа. Гэхдээ энэ нь зохион байгуулагч миний бие 4 сарын 13-наас 18-ны өдрүүдэд томилолтоор ажилласантай холбоотой тул энэ нь хувийн шалтгаан гэж үзэж байна.

Хүндрэлтэй зүйл байсангүй.

Зургаа. Хэлэлцүүлэгт оролцогчдын зүгээс гаргасан цаашид хийх ажлын санал, санаачлага

Оролцогчдоос цаашид хийх ажлын талаар дараах саналууд гарлаа. Үүнд:

-Гэр бүлийн боловсрол, залуу гэр бүлүүдийн хөгжил төлөвшилд чиглэсэн сургалт нөлөөлөл, нийгмийн ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлэх,

-Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд нотлох баримтыг үнэлэх, цуглуулах асуудлыг холбогдох байгууллагууд анхаарах, ялангуяа хохирогчоос нотлох баримтаа гаргаад ирэхийг шаардах нь маш хүнд бөгөөд үүнтэй холбоотой хохирогч хамгаалагдах хууль зүйн боломжоо алдаж байгаа туршлагыг хэлэлцэв.Сум дундын шүүхийн оролцогчид гэр бүлийн хүчирхийлэлийн шалтгаант гэр бүл цуцлуулах нэхэмжлэлийг хүлээн аваад эвлэрүүлэн зуучлалаар дамжуулалгүйгээр шийдвэрлэх, нотлох баримтыг хохирогчоос гаргуулахаар шаардахаас татгалзаж байгаа шүүхийн практик тогтоож байгаа талаар нэгдэн ойлголттой болов.

-Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг соёл урлагын байгууллагуудтай хамтран зохион байгуулах, урлагаар дамжуулан сурталчлах ажил хийх

-Албадан сургалтын ажлыг хэрэгжүүлэхэд хуулийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллах,

Долоо.Та бүхэн тус хэлэлцүүлгийг хэрхэн үнэлж байна вэ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлгийг орон нутагт зохион байгуулж байгаа нь цаг үеэ олсон, нийгмийн хэрэгцээг хангасан чухал ач холбогдолтой ажил болж байгааг хэлэлцүүлэгт оролцогчид дурьдаж байлаа.

Мөн шинэ хуулийн төсөл нь агуулга, зохицуулалтын хувьд шинэ шатанд гарсан хууль болж байна гэж үнэлж байлаа.

ХОЁРДУГААР ХЭСЭГ. УИХ-ын эмэгтэй гишүүдтэй цахим хурал хийх ажлыг зохион байгуулах

Хэлэлцүүлэгт оролцогчдын саналаар Засаг даргын орлогч, иргэдийн хурлын төлөөлөгч Д.Чимгээ, Хууль зүйн хэлтсийн дарга П.Хишигдаваа, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Д.Батмөнх, ЦГ-ын олон нийттэй харилцах албаны ахлах байцаагч Э.Ариунчимэг, Хүний эрхийн мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Эвлэрүүлэн зуучлагч Д.Элбэгзаяа, өмгөөлөгч М.Найдан, эрүүл мэндийн газрын дарга С.Нарантуяа/өрхийн эмч нар/ гэсэн бүрэлдэхүүнийг цахим хуралд оролцохоор сонголоо.

УИХ-ын гишүүнд нөлөөллийн захидал бичих багийг сонгож Даваа гарагт захидлыг хүлээж авахаар хугацааг товлов. Үүнд:

Нийгмийн ажилтнуудын баг, Төрийн бус байгууллагуудын баг, Орон нутгийн төр, захиргааны байгууллагуудын баг гэсэн 3 багаас нөлөөллийн захидал бичихээр шийдвэрлэв.

Зохион байгуулагч: П.Хишигдаваа